

## МЕТАФОР БА КОГНИТИВ ХЭЛ ШИНЖЛЭЛ

Э.Тогтуун<sup>1</sup>

Саяхныг хүртэл манай хэл шинжлэлд зүйрлэл, адилтгал, хэтрүүлэл, төлөөлөл, тойруулал, егөөдөл зэргийг уран зохиолын асуудалд хамруулан, уран найруулгын дүрслэх хэрэглүүр гэж үзэх мөртлөө өвөрмөц хэллэг, хэлц, хэвшмэл хэллэг, зүйр цэцэн үг зэргийг хэл шинжлэлийн асуудалд хамруулан судалдаг байсан билээ. Гэхдээ ингэж үзэх хандлага дан ганц монгол хэл шинжлэлд ч бус, дэлхий нийтэд ийм байсаныг хэлэх хэрэгтэй.

Дэлхийн хэл шинжлэлийн салбарт 1970-аад оны сүүлээс өөрчлөлтийн салхи салхилж, тухайн үеийн хэл шинжлэлийн онолыг “хэт хэв загварт баригдан, утгыг орхисон” хэмээн шүүмжилж гарч ирсэн утга зүйн салбар, хүний хэлийг судлахад дан ганц бүтэц гэсэн өнцөгөөс харах нь дутагдалтай байгааг анхааруулсан. Ингэснээр угсаа хэл шинжлэл, бүтэц хэл шинжлэл, танин мэдэхүйн хэл шинжлэл гэх мэтээр хэлийг янз бүрийн талаас судлах хэл шинжлэлийн онолууд ар араасаа цуварсаар гарч ирсэн нь бодит үнэн юм.

Хэдийгээр 20 гарй жилийн хойно ч гэсэн, 1990-ээд оноос манай Монгол хэл шинжлэл дэлхий нийтийн хэл шинжлэлийг анхааран судалж, өөрийн орны судлагааны арга барил, онол гаргалгаа зэрэгт өөрчлөлт хийж эхэлсэн ба энэ нь тухайн салбарийн хөгжилд тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгч эхлээд байна.

Тухайлбал дээр дурьдаад өнгөрсөн хэлхүйн түвшний асуудлуудыг бүхэлд нь шууд бус нэрлэлт гэсэн нэр томъёонд оруулан, арай өөр байдлаас харж судлах болжээ. Жишээ дурдвал, сэтгэц хэл шинжлэл, утга судлал зэргийг нэрлэж болно.

Бид ч гэсэн, энд авч үзэж буй “шууд бус нэрлэлт” хэмээх ойлголтыг Танин мэдэхүйн хэл шинжлэлийн үүднээс судлаж үзэх цаг үеийн шаардлага гарч ирээд байгааг анхаармаар байна.

Шууд бус нэрлэлтийг Танин мэдэхүйн хэл шинжлэлд Метафор гэсэн нэр томъёо, ухагдахууны дор судалж байна.

Метафор нь Герег хэлнээс гаралтай. Герегээр Metapherein гэж бичдэг. Meta-\\change\\, pherein-\\to bear\\ гэсэн утгатай. Англиар Metaphor гэнэ. Ямар утгатай үг болохыг тайлбар толиос харвал:

A figure of speech in which a term is transferred from the object it ordinarily designates to an object it may designate only by implicit comparison or analogy, as in the phrase evening of life.<sup>2</sup>

<sup>1</sup> МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

<sup>2</sup> The American heritage dictionary. Second college edition. USA. Page 790.

Япон хэлэнд Метафорыг 隱喩、暗喩 гэж орчуулан буулгах ба үүнийг монгол хэлнээ үгчлэн буулгавал “далд зүйрлэл” болно.

Харин Метафорыг Монгол хэлэнд юу гэж буулгах вэ? гэсэн асуудал гарч ирэх боловч, үүнд хариулт өгөхийн өмнө Метафор гэдэг нь юу вэ? гэдэгт хариулт өгөх хэрэгтэй болов уу.

Метафор нь хүний өдөр тутмын амьдралд байнга хэрэглэгдэж байдаг төдийгүй яруу найраг, уран зохиолын төрөл зүйлд хүртэл арвин баялаг орсон байдаг төдийгүй Р.Якобсоны хэлснээр “ бүх үгэлбэр нэг бол метафорик нэг бол метонимик хэв шинжид хамаардаг” байна.<sup>3</sup>

Орчин үед Метафор ба Метонимийг Танин мэдэхүйн хэл шинжлэлийн судалгааны нэг төрөл зүйл болгон авч судалдаг ба бид энд Метафорын тухай авч үзнэ.

Танин мэдэхүйн хэл шинжлэл гэж юу вэ? Энэ шинжлэх ухаан бол хэлийг хүний танин мэдэхүйн үйл ажиллагааны нэг хэсэг хэмээн үзэж, хүн ба соёлын харилцааны мөн чанарыг судлан нээхийг зорилгоо болгодог байна. Статистик аргыг хэл шинжлэлийн судалгааны гол зарчимаа болгодог хэлнүүдийн нийтлэгийн онолтой харьцуулан үзэхэд, танин мэдэхүйн хэл шинжлэл нь утга зүйн онолыг голчлон судалдаг тул танин мэдэхүйн утга зүйн онол ч гэж бас хэлдэг байна.<sup>4</sup>

Энэхүү хэл шинжлэлийн онолыг 1970-аад оны үед Калифорны их сургуулийн Жорж Лакофф, Марк Жонсон нарын хэсэг эрдэмтэд анх гаргаж иржээ. Эдгээр эрдэмтэд нь, хэлнүүдийн нийтлэлийн онолоор замнагч нарын үл ойшоосон Метафор ба Метоним зэрэг хэлэхүйн үзэгдэлийг, танин мэдэхүйн сэтгэл судлалын шинжлэх ухааны баримталдаг Прототайп онолын<sup>5</sup> аргаар тайлан уншихыг оролдсон байна. Өөрөөр хэлбэл эдгээр хэлэхүйн үзэгдэлд хэлнүүдийн түгээмэл онолыг баримталдаг онол дүрмийн зарчим механизм огт үйлчлэхгүй. Харин хүн төрөлхтөний аливаа юмыг үзэх үзэл, угсаатны шинжтэй үзэгдлээс үүдэлтэй мэдрэмжээс эхтэй хэмээн үзсэн байдаг. Философийн салбарт баримталдаг утга зүйн онолын уламжлалыг авч, түүнийг бие даасан шинжтэйгээр цааш дэлгэрүүлэн хөгжүүлсэн Танин мэдэхүйн хэл шинжлэл нь хэлний шинжлэлийн хэтэрхий явцуу бас тэгээд субъектив шинжтэй, хэлний хэв загварт баригдсан энэхүү хөгжил нь цаашид явуургүй болсоныг цохон тэмдэглэжээ. Хэл шинжлэлийн энэ онол нь хүн төрөлхтөний сэтгэл санаа, бие махбод, орон зайн мэдрэмжинд тулгуурласан хэлний хөгжлийг анхааран судалдагаараа маш богино хугацаанд эрчимтэй хөгжиж чадсан гэж хэлж болно.<sup>6</sup>

Энгийн жишээ авч үзэхэд, интернетийн сайтаас танин мэдэхүйн хэл шинжлэлийн тухай мэдээ хайхад, энэ талаар 1800000 орчим мэдээ мэдээлэл гарч ирж байна.

Хэлнүүдийн түгээмэл онолыг баримтлагч нар, Танин мэдэхүйн хэл шинжлэлийн онолын тухай янз бүрээр шүүмжлэл хэлдэг байна. Тухайлбал “ Философи хэл шинжлэл

<sup>3</sup> М.Ууганбаяр. МУИС.МХСС.Монгол Судлал. 2007 он.

<sup>4</sup> Интернет толь бичиг Wikipedia.

<sup>5</sup> Прототайп онолыг анх 1970 онд Эланор Роч (Eleanor Rosch) тэргүүтэй хэсэг эрдэмтэд гаргаж ирсэн байна. Энэ нь Танин мэдэхүйн хэл шинжлэлийн баримталдаг гол онол ба хүний оюун ухаанаар хийх аливаа юм үзэгдэлийг зүйлчлэн ангилах процесс нь ямар нэг шаардлага гарах үед л явагддаг гэж үзэж байсан уламжлалт ойлголтоос өөр юм. Харин энэ онол нь юм үзэгдэлийг ангилан зүйлчилэхдээ тухайн нэг зүйлийн бусдаас ялгарах шинж ба түүнтэй ижил төсөөтэй шинжид тулгуурлан нэг хэсэг зүйлийг онцгойруулан авч үздэг байна.  
[ja.wikipedia.org/wiki/プロトタイプ](http://ja.wikipedia.org/wiki/プロトタイプ)

<sup>6</sup> Интернет толь бичиг Wikipedia.

хоёрын эрлийз” ч гэх юмуу. Эсвэл “ Субъектив шинжгүй. Хэт объектив шинжтэй, бүдэг бадаг нийтлэлээс хэтрээгүй.” гэхчилэн шүүмжилсэн байна. Гэхдээ энд нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. Энэ нь юу вэ? гэвэл тус хоёр онолын өөр өөрийн баримталдаг зарчимын хоорондын ялгаа юм.

Энэ ялгаа нь: Хэлнүүдийн нийтлэлийн онол нь тухайн хэлний үзэгдэл нь дүрмийн шинжтэй, аль эсвэл тийм бус шинжтэй гэсэн таамаглалыг дэвшүүлэх боломж байгаа эсэхийг чухалчилан үздэг. Харин танин мэдэхүйн хэл шинжлэл нь тухайн хэлний үзэгдэлд хийгдэх тайлбарыг чухам ямар утгын учир холбогдолд тулгуурлан хийх вэ? гэдэгт ач холбогдол өгдөг. Өөрөөр хэлбэл 1-р онол нь бүтэц загварт шүтсэн байдаг бол, 2-р онол нь учир шалтгааныг дээдлэн үздэг байна.<sup>7</sup>

Тэгэхээр бидний энд ярианыхаа сэдэв болгон аваад байгаа метафор нь хэл шинжээчидийн дунд хэрхэн юу гэж яригдаж байсан юм болоо?

Метафорыг үзэх үзлийн түүхэн хөгжлийн тухай авч үзэхэд, Метафор нь эрт эдүгээгийн өрнө дорнын утга уянгын зохиол бүтээлд түгээмэл хэрэглэгдсээр ирсэн байна. Үүнийг хамгийн анх анзаарч, түүний ач холбогдолын тухай онцгойлон дурьдсан хүн бол Аристотель юм. Тэрээр “Туурвил зүй “ бүтээлдээ Метафорын тухай ийн өгүүлсэн байна.

“Хамгийн агуу хүн бол Метафорыг зохиогч мэргэжилтэн юм. Өдөр тутмын хэрэглэж байдаг үг хэллэг бол аль эрт мэдэгдсэн зүйлийн тухай л мэдээллийг өгнө. Бид хэрвээ шинэ соргог ямар нэгэн мэдээллийг олж авлаа гэж бодох л юм бол, түүнийг гагцхүү метафор л хэлж өгдөг”<sup>8</sup>

Тэгэхээр Аристотелийн хэлээд байгаа “шинэ соргог мэдээ мэдээлэл” гэж чухам юу вэ? Энэ нь өгүүлэгдэн буй өгүүлбэрийн утга санаа нь, түүнийг бүрдүүлэгч үгсийн утгатай шууд хамааралгүй байх бөгөөд өөр нэг утга санааг тэдгээр үгсээр төлөөлүүлэн илэрхийлж байгаа өөр нэгэн утга санаа нь юм. Энэ өөр нэг утга санаа гэдэг нь Аристотелийн хэлээд байгаа “шинэ соргог мэдээ мэдээлэл” болж өгнө.

Харин танин мэдэхүйн хэл шинжлэлийг үндэслэгч Жорж П Лакофф, Марк Жонсон нар нь Метафор бол найруулгын төдий асуудал бус, бид бүхний үндсэн танин мэдэхүйн чадварын нэг мөн хэмээн үзэж, асуудлыг дэвшүүлэн тавьсан байна.

Жорж П Лакофф \George P Lakoff\ 1941 онд төрсөн. АНУ-ын хэл шинжээч. Калифорнын их сургуулийн Ваакрэй салбар сургуулийн профессор. Тэрээр анх хэлнүүдийн түгээсэл онолыг баримтлагч байсан байна. Гэвч өөрийнх баримталдаг байсан онол нь хэлний зарим нэг үзэгдлийн тухайд, тухайлбал “Утга шилжих үзэгдэл, Хэлний гүн ба өнгөн бүтэц “ зэрэг онолын шинжтэй ухагдахууныг үндсэндээ үгүйсгэж байлаа. Энэ саналтай Лакофф үндсэндээ санал нэгдээгүй ба өөрийн онолын урсгалаа гаргаж ирсэн.

Аливаа шинжлэх ухаан бол өөрийн судалгааны эхлэлийн цэг болох “ Юуг судлах вэ? ” гэсэн асуултгүйгээр оршин тогтнохгүй. Цаашлаад судлагааны объектийн аль нэг хэсэгт нуугдан байх сонин хачин үзэгдэл юмсыг нээн олж гаргах үүрэг судлаачдад оногддог.

Бид бүхний өдөр тутам хэрэглэж байдаг үг хэллэг өөрөөр хэлбэл хэлний тухайд ч, мэдээж хэрэг олон сонирхолтой асуултууд байдаг болов уу. Түүн дундаас эхлэлийн цэг болдгоороо анхаарал тавиуштай зүйл бол дараах үзэгдэл юм.

<sup>7</sup> Когнетив хэл шинжлэл. Тошио Оохори. Токиогийн их сургуулийн хэвлэлийн газар. Япон. Хуудас 6-9.

<sup>8</sup> Туурвил зүй. Аристотель. Япон орчуулга.

Хүний амнаас гарах авиа нь “ амьсгаа ” төдий зүйл юм. Тэгсэн хирнээ бид бүхэн хэлээр дамжуулан аливаа үзэгдэл юмсыг зураглан гаргаж, харилцагч этгээдтэйгээ ойлголцож чадаж байгаа нь бодоод үзэхэд гайхалтай үзэгдэл юм. Ийм үйлдлийг хийж чадаж байгаа нь бид бүхэн хүлээн авч байгаа хэлнийхээ утгыг ойлгож, түүгээр дамжуулан нэгэн ертөнцийг бүтээж байгаа болохоор тэр юм. Энэхүү үзэгдэл хэрхэн яаж бий болдог вэ? гэвэл хүний сэтгэлийн хөдлөл, өөрөөр хэлбэл мэдрэн хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааны явцад бүрэлддэг байна.

Хэл, хүний өөрийн биеэр туулах ертөнцийг хэрхэн бүтээж байдаг юм бол? Мөн тэрхүү ертөнц нь ямар онцлогийг агуулж байдаг бол? Танин мэдэхүйн хэл шинжлэл Когнитив хэл шинжлэл нь дээрх асуултанд хариу өгдөг.<sup>9</sup>

Өөрөөр хэлбэл Японы эрдэмтэн Оохоригийн тодорхойлчилсончлон Танин мэдэхүйн хэл шинжлэл нь бид бүхний хэлээр дамжуулан бодит байдлыг ухаан ойлгож, түүндээ хариу үйлдэл хийдэг бүтцийг тодорхой болгохыг зорилгоо болгодог шинжлэх ухаан гэж хэлж болно.

Харин одоо эргээд Метафор уруугаа орьё.

Бодит юмсын тухай ойлголтыг өдөр тутмын амьдралд тохиолдох үзэгдэл юмст тулгуурлан ухааран мэдэж авдаг боловч “үхэл” ч юмуу “цаг хугацаа” гэхчилэнгийн хийсвэр ойлголтыг хэрхэн яаж ухааран ойлгож, тэр нь бидний амьдралтай хэрхэн яаж холбогддог болоо<sup>10</sup> гэсэн сонирхолтой асуултыг Японы хэл шинжээч Т.Оохори дэвшүүлж, түүндээ дараах хариултыг өгсөн байна.

Тэрээр “Мэдээллийн урсгал муу байна.” , “Хүний амьдрал бол аялал юм” гэсэн өгүүлбэрийг жишээ болгож авч, тус тусад нь холбоо бүхий өгүүлбэрээр дэлгэрүүлэн тайлбар хийсэн байна.

“Нүдээр харж, гараар барьж болохгүй “Мэдээлэл”, “Хүний амьдрал” –ийн янз бүрийн учрал тохиоллыг, бодит шинж бүхий үзэгдэл юмстай холбон, тухайн зүйлийнхээ шинж байдлыг тодорхойлж байна. Өөрөөр хэлбэл, “Мэдээлэл” бол “Шингэн”, “Амьдрал” бол “Аялал” –ын шинжийг агуулж байгаа тул эдгээр бодит үзэгдлээр төлөөлүүлэн гаргажээ. Иймэрхүү маягийн хийсвэр ухагдахуун болон тодорхой юмс үзэгдлээс тогтсон бодит ухагдахуун хоёрын дунд бүрэлдэн тогтсон тогтвортой, харилцан хамаарал бүхий харилцааг Метафор гэж хэлнэ “ гээд, цаашлаад энэ нь хэдийгээр зүйрлэлийн шинжтэй боловч, утга зохиолын ойлголтод багтдаг чимэг төдий зүйл биш, харин ч өдөр тутмын амьдралд тохиолдож, хэрэглэж байдаг юм гэж дүгнэжээ.<sup>11</sup>

Тэгэхээр хэлц, зүйр цэцэн үг, хэвшмэл хэллэг, нь бүгд Оохоригийн тодорхойлсоны адил “хийсвэр ухагдахуун болон тодорхой юмс үзэгдлээс тогтсон бодит ухагдахуун хоёрын дунд бүрэлдэн тогтсон тогтвортой, харилцан хамаарал бүхий харилцаа”-наас бүтсэн байдаг тул нэг бол метафор нэг бол метоними болно. Харин

<sup>9</sup> Когнитив хэл шинжлэл. Тошио Оохори. Токиогийн их сургуулийн хэвлэлийн газар. Япон. хуудас 1.

<sup>10</sup> Когнитив хэл шинжлэл. Тошио Оохори. Токиогийн их сургуулийн хэвлэлийн газар. Япон. хуудас 73.

<sup>11</sup> Когнитив хэл шинжлэл. Тошио Оохори. Токиогийн их сургуулийн хэвлэлийн газар. Япон. хуудас 74.

зүйрлэл, адилтгал, хэтрүүлэл, төлөөлөл, тойруулал, егөөдөл зэрэг нь метафор ба метонимийн илэрхийлэх утга болов уу хэмээн миний бие ойлгоно.

Дээрх тодорхойлолтоос харахад метафорын гол зарчим бол:


1. Тодорхой юмс үзэгдэлээс хийсвэр ухагдахуун урган гарах
2. Шинээр бий болж буй ухагдахуун нь эхний үзэгдэлийнхээ шинж тэмдэгийг агуулах
3. Тогтвортой шинжтэй байх болно.

Танин мэдэхүйн хэл шинжлэлд метафорыг дараах маягаар томъёолдог байна.

Бодит ухагдахууныг source domain , хийсвэр ухагдахууныг target domain , урган гарах явцыг mapping гэж томъёолно. Харин эдгээр нэр томъёог Монгол хэлнээ хэрхэн яаж буулгах вэ? Японы хэл судлаачид source domain- ыг 根源領域 (эх сурвалжийн хүрээ), target domain -ыг 目標領域( зорилгын хүрээ), mapping -ыг 写像 (дүрслэн буулгалт) гэж орчуулсан байна. Энэ томъёог загварт оруулбал доорх маягтай болно.

**source domain**  
эх сурвалжийн хүрээ

**target domain**  
зорилгын хүрээ



Энэ бүхнээс үзэхэд шууд бус нэрлэлт бол :

1. Хүний танин мэдэхүйн процессын үр дүнд бий болдог, маш нарийн бүтэцтэй хэлэхүйн үзэгдэл юм.
2. Түүний өгүүлбэрт илрэх байдал нь нэг бол метафор нэг бол метоними байна.
3. Гийнхүү бий болсон шууд бус нэрлэлтээр дамжуулан тухайн нэг үндэстэн угсаатан, тодорхой нэг юмс үзэгдэлийг хэрхэн ухаарч, түүндээ ямар үнэлэмж өгч байгааг задлан дүгнэх боломжийг олгоно.

Дахин хэлэхэд, бидэнд зүйрлэл, өвөрмөц хэлц, хэвшмэл хэллэгийг өөр талаас шинжлэн судлах шаардлага гарч ирээд байна.

## Ашигласан материал

1. The American heritage dictionary. Second college edition. USA.
2. М.Ууганбаяр. “Метоним, метафор хэмээх ойлголт ба эхийг унших ерөнхий загварын нэгэн жишээ” МУИС.МХСС.Монгол Судлал. ЭШБ. 2007 он.
3. Интернет толь бичиг Wikipedia.
4. Когнетив хэл шинжлэл. Тошио Оохори. Токиогийн их сургуулийн хэвлэлийн газар. Япон.
5. Туурвил зүй. Аристотель. Япон орчуулга. “Интернет толь бичиг Wikipedia”.

## SUMMARY

Metaphor is defined as follows:

1. Not only are metaphors a result of human cognitive process, but also are phenomena in speech which have a detailed structure.
2. A certain ethnic group of people expresses his idea of understanding through metaphors that give a wide opportunity to analyze and evaluate the social and natural aspects.

To say again, there is necessity to look into the study of metaphor from the different angle.